



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 15 өдөр

Дугаар А/Н

Амардалай

Өвс тэжээл хүлээн авах ажлын хэсэг
томилох тухай

Монгол улсын Засгийн газрын 2020 оны 19 дүгээр тогтоолыг үндэслэн
ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг: Мал хамгаалах сангийн хөрөнгөөр нийлүүлэгдэж байгаа өвс, тэжээлийг
хүлээн авах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Баатарсүрэн /3-р багийн Засаг дарга/

Гишүүдэд: Б.Гарьдмагнай /ХААТ-ийн мэргэжилтэн/

Б.Энхманлай /Нягтлан бодогч/

Б.Баярмаа /Нярав/

Б.Дэлгэрсайхан /Жолооч/

Хоёр: Нийлүүлэгдэж байгаа өвс, тэжээлийг нүд үзэн, чанартай тоолон,
холбогдох бичиг баримтыг бүрдүүлж, шалгаж хүлээн авахыг Ажлын хэсэгт
даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

М.БАЯРСҮХ

4880100032